

ШИФР : 04/21

УЛААНБААТАР-ДАРХАН ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМЫН 112 ДАХЬ КМ
ОРЧМООС ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ТАЛБУЛАГ
/БАЯНБУЛАГ БАГ/, ЗАГДАЛ БАГ, СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОН
СУМЫН БЭЛЭНДАЛАЙ СУУРИН, ДАРХАН-ЭРДЭНЭТ ЧИГЛЭЛИЙН
УЛСЫН ЧАНАРТАЙ АВТО ЗАМЫН ОРХОН СУМЫН
УУЛЗВАРТАЙ ХОЛБОХ 92.13КМ АВТО ЗАМЫН
ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ

БОТЬ-6/11

ТАЙЛБАР БИЧИГ

ШИФР : 04/21

УЛААНБААТАР-ДАРХАН ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМЫН 112 ДАХЬ КМ
ОРЧМООС ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ТАЛБУЛАГ
/БАЯНБУЛАГ БАГ/, ЗАГДАЛ БАГ, СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОН
СУМЫН БЭЛЭНДАЛАЙ СУУРИН, ДАРХАН-ЭРДЭНЭТ ЧИГЛЭЛИЙН
УЛСЫН ЧАНАРТАЙ АВТО ЗАМЫН ОРХОН СУМЫН
УУЛЗВАРТАЙ ХОЛБОХ 92.13КМ АВТО ЗАМЫН
ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ

БОТЬ-6/11

ТАЙЛБАР БИЧИГ

ЗАХИРАЛ  /Б.АНАНДА/ИНЖЕНЕР  /Г.ЭНХЦЭЦЭГ/

УЛААНБААТАР 2021

I. ГАРЧИГ		ХУУДАС
НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА		2
1.1	Оршил	2
1.2	Зураг төсөл боловсруулах үндэслэл, норм, стандартууд	2
1.3	Зураг төслийн товч танилцуулга, бүрэлдэхүүн, үндсэн үзүүлэлтүүд	2-8
ХОЁР. ХАЙГУУЛ СУДАЛГАА		8
2.1	Байгаль орчин, цаг уурын байдал	7-15
2.2	Байр зүйн зураглал	15-29
2.3	Замын дагуух буурь хөрсний судалгаа	29-35
2.4	Ус зүйн судалгаа	35-45
ГУРАВ. ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ		45
3.1	Замын төсөллөлт	45
	3.1.1. Стандарт шалгуур үзүүлэлтүүд, замын үндсэн элементүүдийн сонголтууд	45-46
	3.1.2. Төсөллөлтийн хамгийн бага үзүүлэлтүүд	46-48
	3.1.3. Хөндлөн огтлолын төрөл, хучлагын хийц, тооцоо, үндэслэл	48-53
	3.1.4. Трасс сонголт , хэвтээ төлөвлөлт	53-76
	3.1.5. Замын дагуу төлөвлөлт	77-85
	3.1.6. Төмөр зам дээгүүр баригдах 25.10 у/м төмөр бетон гүүр	85-96
	3.1.7. Гарц орц, уулзвар төсөллөлт	96-98
	3.1.8. Төмөрбетон хоолойн төрөл, хийц	99-112
	3.1.9. Хажуугийн шуудуу төсөллөлт	112-114
3.2	Хөдөлгөөн зохион байгуулалт, тоноглол	114-117
	3.2.1. Ажлын тоо хэмжээ	118-126
ДӨРӨВ. ХАВСРАЛТУУД		127-157

НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. ОРШИЛ

13/21 дугаартай ажлын даалгаврын дагуу “Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг /Баянбулаг баг/, Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох” 92.13км авто замын инженерийн нарийвчилсан зураг төслийг 2021 оны 11 сард боловсруулав.

1.2. ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ, НОРМ, СТАНДАРТУУД

Зураг төсөл боловсруулах үндэслэл:

- Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан 13/21 дугаартай “Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг /Баянбулаг баг/, Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто замын инженерийн нарийвчилсан зураг төслийг боловсруулах ажлын даалгавар”

Ашигласан норм, стандартууд:


Инженерийн нарийвчилсан зураг төслийг боловсруулахад Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дараах БНБД, норм стандартуудыг ашиглав. Үүнд

- Авто зам төсөллөх ЗЗБНБД 22-004-2016
- Авто замын гүүр ба хоолой төсөллөх БНБД 32-02-12
- Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл АЗУАГН 2.01.01-2004
- Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх БНБД 22.01.01*/2006
- Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар MNS 6056:2009
- Хот суурины гудамж зам төлөвлөлт БНБД 32-01-04

1.3. ЗУРАГ ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, БҮРЭЛДЭХҮҮН, ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Төслийн зам нь Төв аймгийн Жаргалант, Сэлэнгэ аймгийн Орхон сумдын нутаг дэвсгэрт баригдана. Төлөвлөж буй зам нь Улаанбаатар-Дархан хот чиглэлийн авто замын 112 дахь км-ийн орчмоос Жаргалант сумын асфальтбетон замыг даган Баянбулаг багийг өнгөрөөд баруун гар тийш салж, Хуштын нурууны араар яван Загдалын голыг гарч, тариан талбайн дундуур яван Загдал бригадаар дайрч, Зөөхийн хөндийг хөндлөн гаран, Жавхлант уулын баруун амаар өгсөн Шар хөтөлөөр даван Шивнээт уулын зүүн

бэлээр тойрон Бэлэндалай суурингийн зүүн талаар төмөр замын хуучин гармаас зүүн тийш 75м-н орчим зайтайгаар 2 түвшинд төмөр замыг огтлон гарч, Нарт овооны баруун бэлээр яван, Дархан-Эрдэнэтийн замын Орхон сумын замын уулзварт хүрч дуусна.



Зураг 1.3.1. Замын трассын бүдүүвч

Замын дагууд орц, гарцыг 11 байрлалд, нэг төвшингийн тойрог уулзварыг Баянбулаг багийн баруун урд Жаргалант сумын замаас баруун гар тийш салах хэсэгт болон Орхон сумын уулзварт 2 цэгт, ус гаргах хоолой 108 цэгт, туннель 1 цэгт баригдах бөгөөд Загдалын гол дээр 26.08 у/м, Бэлэндалай суурингийн хажууд төмөр замын дээгүүр гарах 25.10 у/м төмөрбетон гүүр 1ш, газрын гадаргын онцлог, хөрсний үзүүлэлт зэргийг харгалзан 8.22 км урт уулын шуудууг төлөвлөв.

Төлөвлөж буй хоолойноос 1 нь том оврын ачааны машин, 17 нь мал, амьтан ердийн хөсөг, бага оврын тээврийн хэрэгсэл, 43 нь мал амьтан зам хөндлөн гарахад ашиглагдана. Хүн, мал амьтан зам хөндлөн гарах хоолойн байрлалыг хүснэгт 1.3.2-т үзүүлэв.

Хүснэгт 1.3.2

№	Байрлал (м)	Хоорондын зай (м)	Хэмжээ	Тайлбар
1	12+609	12609	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
2	17+041	4432	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
3	17+810	769	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
4	19+542	1732	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
5	22+115	2573	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
6	23+160	1045	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
7	24+620	1460	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
8	25+921	1301	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
9	27+150	1229	2.50×2.00	Хүн, мал амьтан, жижиг тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд
10	28+418	1268	2.50×2.00	Хүн, мал амьтан, жижиг тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд
11	29+396	978	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
12	31+588	2192	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
13	32+029	441	2×2.50×2.00	Хүн, мал амьтан, жижиг тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд
14	32+614	585	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
15	35+008	2394	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
16	35+841	833	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
17	37+814	1973	3×2.50×2.00	Хүн, мал амьтан, жижиг тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд
18	38+421	607	2.00×2.00	Хүн, мал амьтан, жижиг тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд
19	39+522	1101	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
20	43+207	3685	2.00×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
21	44+314	1107	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
22	45+590	1276	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
23	46+857	1267	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
24	47+636	779	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
25	49+305	1669	2×2.00×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
26	50+424	1119	2×2.00×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
27	52+163	1739	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
28	52+785	622	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
29	54+220	1435	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
30	54+734	514	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
31	56+169	1435	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
32	58+381	2212	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
33	58+941	560	2.00×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд

№	Байрлал (м)	Хоорондын зай (м)	Хэмжээ	Тайлбар
34	60+262	1321	2.50×2.00	Хүн, мал амьтан, жижиг тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд
35	60+719	457	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
36	61+149	430	2×2.00×2.00	Хүн, мал амьтан, жижиг тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд
37	62+562	1413	2.50×2.00	Хүн, мал амьтан, жижиг тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд
38	65+204	2642	2×2.00×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
39	66+734	1530	2.00×2.00	Хүн, мал амьтан, жижиг тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд
40	67+658	924	3×2.50×2.00	Хүн, мал амьтан, жижиг тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд
41	68+316	658	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
42	70+396	2080	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
43	71+499	1103	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
44	71+893	394	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
45	73+213	1320	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
46	74+908	1695	3×2.50×2.50	Хүн, мал амьтан, жижиг тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд
47	77+716	2808	2.00×2.00	Хүн, мал амьтан, жижиг тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд
48	78+737	1021	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
49	79+657	920	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
50	80+606	949	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
51	81+143	537	2.00×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
52	81+772	629	2.50×2.00	Хүн, мал амьтан, жижиг тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд
53	82+377	605	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
54	83+402	1025	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд
55	84+274	872	2.50×2.00	Хүн, мал амьтан, жижиг тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд
56	84+418	144	4.5×4.650	Хүн, мал амьтан, том оврын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд
57	84+612	194	2.00×2.00	Хүн, мал амьтан, жижиг тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд
58	85+461	849	2.00×2.00	Хүн, мал амьтан, жижиг тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд
59	87+137	1676	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд

№	Байрлал (м)	Хоорондын зай (м)	Хэмжээ	Тайлбар
60	89+734	2597	2×2.00×2.00	Хүн, мал амьтан, жижиг тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд
61	90+709	975	1.50×1.50	Хүн, мал амьтаны хөдөлгөөнд

Авто замын зураг төслийн иж бүрдлийг дараах байдлаар багцлав. Үүнд:

Хүснэгт 1.3.3

№	Зургийн иж бүрдэл	Ботийн дугаар
I	Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг /Баянбулаг баг/, Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл	Боть-I
II	Загдал голын 26.08у/м төмөрбетон гүүрийн инженерийн нарийвчилсан зураг төсөл	Боть-II
III	Төмөр замын дээгүүр гарах 25.10у/м төмөрбетон гүүр, төмөр замын холбоо, цахилгаан дамжуулах шугам шилжүүлэх, хамгаалах инженерийн нарийвчилсан зураг төсөл	Боть-III
IV	Холбооны шилэн кабель шилжүүлэх, хамгаалах зураг төсөл	Боть-IV
V	Цахилгаан дамжуулах шугам шилжүүлэх, хамгаалах зураг төсөл	Боть-V
VI	Тайлбар бичиг	Боть-VI
VII	Техникийн шаардлага	Боть- VII
VIII	Зам барилгын ажлын төсөв	Боть- VIII
IX	Авто замын зурвас талбайн инженер геологийн судалгааны ажлын тайлан	Боть-IX
X	Археологийн авран хамгаалах хайгуул судалгааны тайлан	Боть- X
XI	Авто замын хайгуулын ажлын геодезийн хэмжилт, зураглалын ажлын тайлан	Боть- XI

Төсөлд оролцогч байгууллагууд

- Замын трассын дагуух инженер- геологийн болон зам барилгын материалын орд газрын судалгаа – “БИГС” ХХК
- Байр зүйн судалгаа - “Эрин Кадастр” ХХК
- Холбооны шилэн кабель шилжүүлэх, хамгаалах зураг төсөл – “Арбэл-Алтай” ХХК
- Цахилгаан дамжуулах шугам шилжүүлэх, хамгаалах зураг төсөл – “Бодь-Эрчим” ХХК
- Төмөр замын холбоо, цахилгаан дамжуулах шугам шилжүүлэх, хамгаалах зураг төсөл-“УБТЗ” ХНН-ийн Зураг төслийн төв

- Архелогийн авран хамгаалах хайгуул судалгааны тайлан – Шинжлэх ухааны академи. Археологийн хүрээлэн

Төсөллөлтийн үндсэн үзүүлэлтүүд

Авто замын зураг төслийг боловсруулахад “Авто зам төсөллөх ЗЗБНБД 22-004-2016” стандартыг баримтлан төсөллөсөн бөгөөд үндсэн үзүүлэлтүүдийг хүснэгт 1.3.4-д үзүүлэв.

Хүснэгт 1.3.4

№	Төсөллөлтийн үндсэн үзүүлэлтүүд	ЗЗБНБД 22-004-2016 нормын үзүүлэлтүүд	Төсөллөлтийн сонгосон үзүүлэлтүүд
1	Замын ангилал ба зэрэглэл	Зэрэглэл 2А. Аймаг сум хоорондын болон зорчих хөдөлгөөний хэрэгцээг хангахад зориулсан хуримтлуулагч зам	Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг /Баянбулаг баг/, Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох 92.13км авто замын инженерийн нарийвчилсан зураг
2	Жилийн хоногийн дундаж хөдөлгөөний эрчим	200-аас дээш	-
3	Төсөллөлтийн тодорхойлолт	2А-Хр3-ЗХГ-2-80	2А-Хр3-ЗХГ-2-80
4	Тооцоот хурд: Тэгш тал газар	70-80 км/цаг	80
5	Нугачаатай газар	60 км/цаг	80
6	Уулархаг газар	50 км/цаг	60
7	Тооцоот хугацаа	15	15
8	Хөдөлгөөний үйлчилгээний төвшин	D, E	D
9	Трассын шулуун хэсгийн хамгийн их урт	5000м	3668
10	Хамгийн их дагуу налуу: Тэгш тал газар	6%	4.0%


№	Төсөллөлтийн үндсэн үзүүлэлтүүд	ЗЗБНБД 22-004-2016 нормын үзүүлэлтүүд	Төсөллөлтийн сонгосон үзүүлэлтүүд
11	Хамгийн их дагуу налуу: Нугачаатай газар	7%	6%
12	Хамгийн их дагуу налуу: уулархаг газар	9%	6%
13	Хэвтээ муруйн хамгийн бага радиус	250м	600
14	Зорчих зурвасын өргөн	6.0-7.0м	7.0м
15	Хөвөөний өргөн	1.5-2.0м	2.0м
16	Үүнээс хучилттай хөвөөний өргөн	0.5м	0.5м
17	Зогсох үеийн хамгийн бага үзэгдэх зай	130м	150м
18	Гүйцэж түрүүлэх үеийн хамгийн бага үзэгдэх зай	245м	250м
19	Хучилтын хөндлөн налуу	2%	2%

ХОЁР. ХАЙГУУЛ СУДАЛГАА

2.1.БАЙГАЛЬ ОРЧИН, ЦАГ УУРЫН БАЙДАЛ

2.1.1. Байршил

Төлөвлөж буй авто замын зурвас нь УБ – Дархан чиглэлийн авто замаас салаалж одоо байгаа УБ – Жаргалант чиглэлийн авто замыг даган “Тал булаг” багийн төвөөс одоо байгаа авто замаас салаалж баруун хойш чиглэн Хуштын нурууны араар гарч, Жаргалантын голыг гаталж, Загдал багийн төвөөр дайран баруун хойш чиглэж Зөөхийн хөндийг гатлан гарч, Шар хөтөлийг даван Шивнээт уулыг тойрон Хар нүдэн хөндийг дагаж Бэлэндалай сууринг дайран Нилчингийн хөндийг дагаж Дархан – Эрдэнэт чиглэлийн авто зам хүртэл 92.13 км үргэлжилнэ. /Байршлын тойм зураг үз/



Зураг 2.1.1. Байршлын тойм зураг

2.1.2. Уур амьсгал

Судалгааны талбайн уур амьсгалын үзүүлэлтийг "Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл" (АЗУАГН 2.01.01-2004)-ийн үзүүлэлтээр өглөө.

Судалгааны зурвас нутаг дэвсгэр нь байрлалаар дэлхийн бөмбөрцөгийн хойт хагасын дундад өргөрөгт багтдаг учир эх газрын эрс тэс уур амьсгалтай байдаг.

Судалгааны талбай нь Монгол орны авто замын уур амьсгалын бүсчлэлээр Ойт хээр (IIA)-ийн бүсийн Орхон-Сэлэнгийн ойт хээрийн хахир дэд бүсэд хамаарах бөгөөд олон жилийн цэвдэг чулуулаг ховор алаг цоог тархсан бүслүүрт байх ба улирлын хөлдөлт-гэсэлттэй, хүйтний овойлттой болон суумтгай, лёсс маягийн хурдас элбэг тохиолдох онцлогтой. Ойт хээртээ цасархаг, цас борооноос намаг шавар их үүсдэг, хахир хүйтэн жаварлаг хөрс чулуулаг нь гүн хөлддөг бүс юм.

Авто замын уур амьсгалын улирлын үргэлжлэх хугацаа

Бүс	Дэд бүс	Өвөл			Хавар		Зун		Намар
		эхлэх	дуусах	үргэлжлэх хоног	дуусах	үргэлжлэх хоног	дуусах	үргэлжлэх хоног	үргэлжлэх хоног
II	IIA	25.X-9.XI	22.III-27.IV	137-163 /150/	10.V-11.VI	49-65 /57/	6.IX-11.IX	110-141 /126/	43-53 /48/

Хөрс агаарын температурын үзүүлэлт

Бүс	Дэд бүс	Хөрсний гадаргын температур, °C				Агаар орчины дундаж температур, °C		
		Олон жилийн дундаж	Хамгийн халуун	Хамгийн хүйтэн	0°C нэвчих гүн, см	Олон жилийн дундаж	Хамгийн хүйтэн сарын	Хамгийн дулаан сарын
II	IIA	-0...-3	55-60	-45...-55	300-400	-3...-8	-23...-33	15...17

Хөрсний хөлдөлт-гэсэлтийн уур амьсгалын хугацаа

Бүс	Дэд бүс	хөлдөлт			гэсэлт		
		эхлэх	дуусах	хоног	эхлэх	дуусах	хоног
II	IIA	10-20.X	1.IV-10.VI	195-200 /197/	1.IV-20.IV	1.VI-1.VII	51-80 /65/

Монгол орны автозамын бүсүүдийн хөрсний хөлдөлтийн норматив гүн

Бүс	Дэд бүс	Хөрсний хөлдөлтийн норматив гүн, м			
		Шавар, шавранцар	Элсэнцэр, тоосорхог элс	Дунд зэргийн элс, хайргархаг элс	Том хэмхдэст хөрс
II	IIA	2,6	3,1	3,3	3,5

Авто замын уур амьсгалын жилийн 4 улирлын салхины хурд, агаарын даралт, харьцангуй чийгшил

Бүс	Дэд бүс	Салхины хурд, м/с				Даралт, мм Hg баганын өндөрөөр	Харьцангуй чийгшил, %
		өвөл	хавар	зун	намар		
II	IIA	0.7-2.5	2-4	1-2	1-2	550-650	60-70

Авто замын уур амьсгалын бүсүүд дах хур тунадасны хэмжээ, мм

Бүс	Дэд бүс	Хур тунадасны нийлбэр, мм							
		өвөл	хавар	зун	намар	жил	1 хоногт орох борооны хангамж, мм		Борооны хамгийн их орох эрчим, мм/мин
							2%	1%	
II	IIA	10-15	20-70	200-250	25-40	250-350	85	120	1-1.5

Аянга, дуу цахилгаан

Бүс	Дэд бүс	Нийт аянгын үйлчлэл		Нэг аянгын	
		Өдрийн тоо	үргэлжлэл, цаг	үргэлжлэл, минут	1 км ² талбайд ниргэх тоо
II	IIA	30-35	40-50	100-120	6-7

Нойтон цас, хялмаа, мөстлөг

Дэд бүс	Нойтон цастай		Хялмаатай		Мөстлөгтэй		
	Өдрийн тоо	Үргэлжлэх, цаг	Өдрийн тоо	Үргэлжлэх, цаг	Өдрийн тоо	Зузаан, мм	
						10 жилд	5 жилд
IIA	5-10	4-5	8-10	13-15	1-2	15	10

Газрын гадрага дээрх цасны ачаалал

Дэд бүс	Цасны ачаалал, кг/м ²
IIA	60-70

2.1.3. Геоморфологийн хэв шинж

Судалгааны район нь физик-газар зүйн мужлалаар Хангай-Хэнтийн уулархаг их мужийн Сэлэнгэ, Орхоны сав дахь бэсрэг уулс тойрогт хамаарагдана.

Геоморфологийн хувьд Бэсрэг уулын хотгор гүдгэр хэв шинжит гадаргууд хамаарах бөгөөд уулс нь 1700-1900 метр өндөртэй, орой нь бөмбөгөр, хажуу нь нь гол төлөв налуу ба хөрсөн бүрхэвч бүрэлдэн тогтоход тааламжтай нөхцөлтэй байна.

Ил гарсан үндсэн чулуулаг, асга хад ховор бөгөөд жижиг ширхэгт элс, элсэнцэр, шавранцар болон том хэмхдэст хурдасыг хучиж бор шороон хөрс 0.4 метр зузаантай тогтжээ.

Бэсрэг уулсын орой нь ой модны дээд захаас дээш гардаггүй боловч газарзүйн нөхцөлөөс хамаарч бүгд ой модоор бүрхээстэй биш бөгөөд зөвхөн хойд болон баруун зүүн хажуу нь ой модоор бүрхэгдсэн байна.

Энэхүү хэв шинжийн гадаргуугийн уулсын хажуу нь урсгал усны үйл, ажиллагаа болон түр зуурын усны үйл ажиллагаанд өртөж гуу жалгаар нилээд их хэрчигдсэн боловч аль нэг хажуу нь эгц байвч нийтдээ мөлгөрдүү бөгөөд уулс нь харьцангуй нам өндөртэй мөстлөгт өртөж байгаагүй учраас мөстлөгийн ор мөр болох хунх, хөнгий, тэвшин хөндий үзэгдэхгүй байна. Харин гүний гаралтай боржин чулуулаг тархсан хэсэгт хадан цохио, уулын хажуу хормойгоор том бул чулуу бага тархсан бөгөөд жижиг голын хөндийнүүд нь өргөн уудам сайн тогтворжсон шинжтэй байна.

Төлөвлөж буй авто замын зурвас талбай нь жижиг голын хөндий, бэсрэг уулс хоорондын хөндий, бэсрэг уулс толгодын хажуу, хөтөл хэв шинжит гадаргууг дамжин өнгөрнө.

2.1.4. Геологийн тогтоц

Судалгааны район нь геологи-структурынхээ ерөнхий ангиллаар Хойт Монголын атираат структурт хамаарагдана.

Судалгааны зурвас талбай орчмын геологийн тогтцыг Палеозойн настай тунамал болон гүний гаралтай чулуулаг бүрдүүлнэ.

Эдгээр хурдсыг Дөрөвдөгчийн настай элс, шавранцар, элсэн болон шаварлаг чигжээстэй том хэмхдэст хурдас хучиж тогтсон байна. Энэхүү хурдасны зузаан нь харилцан адилгүй бөгөөд хэдхэн метрээс хэдэн арван метр зузаантай байна.

Гүний чулуулаг: Судалгааны зурвас талбайн орчимд дунд-дээд Ордовикийн настай Борооголын, Девоны, дээд Пермь-доод Триасын настай Сэлэнгийн гүний чулуулгуудын бүрдлүүд тохиолдно.

Дунд-дээд Ордовикийн настай Бороо гол гүний чулуулгийн бүрдэл (O₂₋₃). Судалгааны ажил явуулсан талбайд Борооголын бүрдэл нь өргөн тархалттай. Чулуулгууд нь бүрэлдэн тогтохдоо хоёр фазыг дамжиж хөгжсөн байна. Нэгдүгээр фаз нь хоорондоо фацийн шилжилттэй перидотид, габбро, габбродиорит, диоритоос бүрдэх бол Хоёрдугаар фаз нь плагиоборжин, боржиндиоритын фацаас тогтоно.

Девоны гүний чулуулгийн бүрдэл (D). Судалгааны зурвас талбайн дагууд Девоны гүний чулуулгууд нь харьцангуй бага хэсгийн эзлэн оршино. Чулуулаг нь шүлтлэгдүү боржин, шигтгээлэг шүлтлэгдүү лейкоборжин, плагиоборжин риолитдофироос бүрдэх ба элсэн чулуу-занарын жижиг шток, дэл судлуудаас тогтно.

Дээд Пермь-доод Триасын настай Сэлэнгийн гүний чулуулгийн бүрдэл (P_{2-T}). Судалгааны зурвас талбайн дагууд энэхүү чулуулгууд нь бүрэлдэн тогтохдоо хоёр фазыг дамжиж хөгжсөн байна. Хоёрдугаар фаз нь цайвар шаргал өнгийн шигтгээлэг, улаан шаргал өнгийн шигтгээлэг трахириолит, улаавтар ягаан өнгөтэй дунд ширхэгтэй шигтгээлэгдүү грано-сиенитүүдийн дэл судал, линз жижиг штокууд, гранит аплит, кварцын судлууд, Нэгдүгээр фаз нь микродиорит, диорит-порфиритүүдийн дэл судал, афирлэг андезит, сиенит-диорит, микро-габбро дэл судлуудаас тогтоно.

Дөрөвдөгчийн сэвсгэр хурдас: Судалгааны зурвас талбайн дагууд бэсрэг уулын хажуу, бэл хормой, даваа, хуурай амууд, жижиг голын хөндийгөөр тархжээ. Дөрөвдөгчийн настай хурдасыг салхины, делюви-пролювийн, аллюви-пролювийн гаралтай элс, шавранцар болон том хэмхдэст хурдас бүрдүүлнэ.

Салхины гаралтай, дунд-дээд Дөрөвдөгчийн настай хурдас (Q_{II-III}). Энэхүү төрлийн хурдас нь судалгааны зурвас талбайн дагууд бэсрэг уулс түүний хажуу хэсгээр тархах ба V-хэлбэрийн гүнзгий жалгуудаар хэрчигдсэн байдаг. Энэхүү хурдсын гол бүрдүүлэгч нь элс эзэлдэг ба хэмхдэсүүд нь янз бүрийн хэмжээтэй хайрга, том ширхэгт элсний үелэлүүд агуулдаг байна. Эдгээр элс, хайрган үеүүд нь салхины хуримтлал түр зогссон үед хур борооны усны зөөгдлөөр үүссэн бэл-хормойн гаралтай хуримтлал юм.

Делюви-пролювийн гаралтай, дээд-орчин үеийн Дөрөвдөгчийн настай хурдас (Q_{III-IV}). Энэ төрлийн хурдас нь судалгааны зурвас талбайн дагууд бэсрэг уулс түүний хажуу, уулс хоорондын хөндий, хуурай хөндий хэсгүүдээр тархах ба гол бүрдүүлэгч хурдас нь элс, шавранцар болон том хэмхдэст хурдас бүрдүүлнэ.

Аллюви-пролювийн гаралтай, дээд-орчин үеийн Дөрөвдөгчийн настай хурдас (Q_{III-IV}). Энэ төрлийн хурдас нь жижиг голуудын хөндийн хэсгээр тохиолдох ба гол бүрдүүлэгч хурдас нь янз бүрийн ширхэгтэй элс, шавранцар болон том хэмхдэст хурдас юм.

Тектоник: Судалгааны талбай нь Хойд Монголын атриат мужийн Тариат-Сэлэнгийн структур-формацын бүс, Монгол-Өвөр Байгалийн атриат мужийн Хойд Хэнтийн структур-формацийн бүсүүдийн заагийг дамжин байрлана. Энэ хоёр бүс нь Баянголын гүний хагарлаар хиллэдэг.

Тектоник структурын үндсэн бүрдэл каледоны, герцины, платформын гэсэн 3 үеүдэд хуваагдна. Каледоны үе нь түрүү ба жинхэнэ каледоны гэсэн 2 структурын яруст, герцины үе нь геосинклиналийн дахин сэргэлтийн, платформийн үе нь кайнозойн структурын ярусууд юм. Эдгээр структурын ярусууд нь хоорондоо томоохон хэмжээний үл нийцлэгээр зааглагдана.

Түрүү каледоны структурын ярус: Дарханы свитийн терриген-карбонат хурдсаас бүрдсэн өргөгдмөл тогтоц юм. Энэ ярус нь зөвхөн Тариат-Сэлэнгийн структур-формацийн бүсийн хэмжээнд уулсын орчим Баянголын гүний хагарлын бүсийн дагуу нэг тийш уналтай шаантаг маягийн жижиг цухуйц байдлаар илэрсэн. Эдгээр цухуйцууд нь жинхэнэ каледоны структурын субвулкан-интрузивээр зүсэгдэхээс гадна герцины давхцмал структурт үл нийцлэгээр тохиолдоно.

Жинхэнэ каледоны структурын ярус: Монгол-Өвөр Байгалийн атриат системийн захын өргөгдөл болох Хойд Хэнтийн структур формацийн бүсийн хэмжээнд илэрдэг. Энэ ярусыг Хараагийн серийн флиш маягийн хурдас, Борооголын ба Девоны гүний чулуулгийн цогцолборын формацууд бүрдүүлнэ.

Тектоник-денудацын гадаргын тогтоцын хувьд дэлхийн дотоод хүчний үйлчлэлийн нөлөөн дор үүссэн горсть-өргөгдлийн ба грабень-суултын уул, толгодууд хамаарагдана. Горсть-өргөгдлийн уулууд нь ихэвчлэн элэгдэл, өгөршилд хүчтэй орсон гүний чулуулгуудаас тогтоно. Эдгээр нь тектоник хагарлын нөлөөгөөр хэсэгчлэгдсэн бөгөөд дугуй, зууван хэлбэрийн орой, хад цохиорхог хяр бүхий бичил хэвийг үүсгэнэ

2.1.5. Гидрогеологийн нөхцөл

Судалгааны районы газрын доорх ус нь Палеозойн настай интрузив чулуулгийн ан цавын, Дөрөвдөгчийн насны хурдасын ус тархсан бүс юм.

Ан цавын ус нь булаг хэлбэрээр тохиолдох бөгөөд ундарга нь ихэнхдээ тогтмол ба 0.15-1.5 л/сек хооронд хэлбэлздэг байна. Энэхүү булгуудын зарим нь Дөрөвдөгчийн насны хурдасны устай хамт нэгэн уст давхрага тогтоно. Газрын доорх усны химийн найрлага нь ерөнхийдөө Гидрокарбонат-кальци, Гидрокарбонат-натрийн төрлийн усанд хамаарна.

Дөрөвдөгчийн насны хурдас дахь газрын доорх ус нь аллювийн ус болон делюи-пролювийн ус хамаарна. Аллювийн ус нь голын гольдролд хэдхэн метрээс илэрдэг бөгөөд хаяа голын татмыг намагжуулдаг, голын дэнжийн хэсэгт энэхүү ус нь хэдэн метрээс хэдэн арван метр гүнээс илэрнэ. Усны ундарга нь 0.5-4 л/сек хооронд хэлбэлздэг, химийн найрлагын хувьд Ц-12-т хөрсний ус 3.2 метр, Ц-88-д 2.6 гүнээс илэрсэн бөгөөд Гидрокарбонат-сульфат ангийн кальци натрийн бүлгийн II төрлийн найрлагатай, саармаг орчинтой, цэнгэг, зөөлөн ус, “Бетон болон барилгын зуурмагт хэрэглэх ус техникийн нөхцөл” УСТ-3921:85-ын стандарт заалтыг хангана гэж тогтоогдсон байна.

Дөрөвдөгчийн насны газрын доорх ус нь голын ус, ан цавын ус болон агаарын хур тунадасны усаар тэжээгдэх бөгөөд дулааны улиралд хөрсний ус тэжээмжээсээ хамаарч түвшин нь 0.5-1.0 метрээр дээшлэнэ.

2.1.6. Ус зүй

Судалгааны район нь усзүйн хувьд Умард мөсөн далайн ай савд хамаарна. Энэхүү ай савд Монгол орны нутаг дэвсгэрийн 20.6% хамаарах ба гол мөрний бүх урсацын 52.1% бүрэлддэг байна. Усан сүлжээний нягтшил, гадаргын урсац ихтэй байна. Гол мөрний нягтшил 0.07км/км² бөгөөд тэжээлийн төрлүүд нь гүний ус 20-35%, борооны ус 40-50%, цасны ус 15-20%-ийг эзэлнэ.

Урсацын жилийн тархалт нь тэжээлээсээ хамаарч сар улирлаар харилцан туйлын адилгүй бөгөөд хаврын их зарцуулга нь 4-р сарын дунд орчимоос 5-р сарын дунд үе хүртэл үргэлжилнэ энэ нь цас хайлж хаврын шар усны үер үүсэхтэй холбоотой. Цас хайлахдаа ихэнх нь уурших, хөрсөнд нэвчих зэргээс хамаарч багахан хэсэг нь шар усны үерийг үүсгэнэ. Хаврын шар усны үер өнгөрсний дараах хугацаанд хур бороо бага, ууршилт их болдогоос голын усны зарцуулга татарч хавар зуны завсрын үеийн усны нам түвшин тогтож бараг 7-р сар хүрнэ. Хур тунадас их унадаг 7, 8-р сар хаяа 9-р сард голын усны зарцуулга нэлээд их нэмэгдэж жилийн бүх урсацынхаа 60-80%-ийг өнгөрөөнө. Жижиг голууд 12-р сард ёроолгүй хөлдөж урсацгүй болдог байна. Жижиг голуудын усны эрдэсжилт нь 100-200 мг/л байна.

Төлөвлөж буй авто замын зурвасын дагууд томоохон гол мөрөн, нуур үгүй бөгөөд жижиг гол, сайрууд хэд хэд тохиолдоно. Жишээ нь: Тал булгийн гол, Жаргалантын гол, Загдал гол, Зөөхийн сайр, Шийрийн гол зэрэг болно. Энэхүү голууд нь одоо усгүй хуурай сайр мэт байгаа бөгөөд хаврын шар усны үерийн үед болон хур бороо их хэмжээгээр орсон үед усжин түр зуурын урсгал устай болдог байна. Дээрх голуудаас дулааны улиралд байнгын урсгалтай байдаг голууд нь Жаргалант, Загдал гол болон Шийрийн гол юм.

2.1.7. Уул зүй

Судалгааны район нь бэсрэг уулын хотгор гүдгэрт хамаарах бөгөөд энд Соёо уул (1355.6), Нарийн толгой (1261.4), Хуштын нуруу (1153.3), Шар чулууны гозгор (1220.5), Үзүүр толгой (1057.3), Хунгар толгой (1016.6), Хүйс толгой (906.7), Жавхлант (1374.7), Шивнээт уул (1373.2), Тэмээн чулуу (1098.3), Дэргээч уул (1042.8), Нарт хонгор овоо (935.3), Худгийн гозгор (837.0) зэрэг улсаар тус тус хүрээлэгдсэн. Авто замын зурвасын дагууд Шар хөтөл даваа гэсэн нам өндөртэй давааг давж, уулс хоорондын бэсрэг хөндий болон жижиг голын хөндий, ухаа толгодорхог гадаргуу болон хажуу хэсгийг дамнан үргэлжилнэ.

2.1.8. Физик-геологийн үзэгдэл, үйл явц

Авто замын зурвасын дагууд физик-геологийн үзэгдэл нилээд хөгжсөн байна. Эдгээр үзэгдэл, процессыг 2 ангилан үзлээ.

1. *Намагжих үзэгдэл:* Төмөр замын Бэлэндалай өртөөний гарамын орчим ПК-84+200-аас ПК-84+800 хэсэгт намагжих процесс ажиглагдана.

2. *Түр зуурын урсгал усны үйл ажиллагаа:* Энэ үзэгдэл авто замын зурвасын дагууд түгээмэл ажиглагдана. Хаврын улиралд цасны ус хайлах, дулааны улиралд орсон их хэмжээний хур тунадасны усаар түр зуурын үерт автах нөхцөлтэй.

2.1.9. Олон жилийн цэвдэг

Судалгааны зурвас талбай нь улирлаар хөлдөж гэсдэг бүслүүрт болон олон жилийн цэвдэг тохиолдлын тархалттай бүслүүрт хамаарч байгаа бөгөөд өрөмдлөгөөр олон жилийн цэвдэг хөрс илрээгүй.

2.2. БАЙР ЗҮЙН ЗУРАГЛАЛ

2.2.1 Ажил гүйцэтгэх үндэслэл

- Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Газрын тухай хууль
- Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль
- Геодези, зураг зүйн тухай хууль
- Авто замын тухай хууль
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль

2.2.2 Хийгдэх ажлын бүрдэл

“Эрдэнэт-Жаргалант чиглэлийн авто замын зураг төслийн ажлын геодезийн хэмжилт зураглалын ажил” нь дараах хэсгүүдээс бүрдсэн. Үүнд:

- Хуучин цэг, тэмдэгтийн судалгааны ажил;


- Шинэ цэг, тэмдэгтийн суулгалтын ажил;
- Геодезийн сүлжээний хэмжилт, боловсруулалтын ажил;
- Нивелирдлэгийн III ангийн хэмжилт, боловсруулалтын ажил;
- Байр зүйн зургийн хээрийн хэмжилт, боловсруулалтын ажил.

2.2.3 Холбогдох дүрэм, заавар, гарын авлага

Уг ажлыг доорх техникийн шаардлага, заавар, стандартыг баримтлан гүйцэтгэсэн. Үүнд:

- “Геодезийн байнгын цэг, тэмдэгт байгуулах ажил” БД 11-104-06*/16
- “Хиймэл дагуулын геодезийн сүлжээний байнгын цэг, тэмдэгт байгуулах заавар” ГЗЗНД-01-1/2003
- “Хиймэл дагуул (GPS/ГЛОНАСС)-ын технологиор монгол улсын геодезийн сүлжээ байгуулах үндсэн дүрэм” БнБД 14-101-08
- Том масштабын байр зүйн зураглал, кадастрын зураглалын ажилд GPS-ийн сүлжээг өтгөрүүлэх гарын авлага, 2010 он
- “1:500, 1:1000, 1:2000, 1:5000-ны масштабтай байр зүйн дэвсгэр зураглалын ажил” БД 11-106-08
- Geocalc программ дээр ТМ солбицлоос UTM солбицол руу хөрвүүлэх гарын авлага, 2010 он
- Том, дунд масштабтай байр зүйн зураглалд ашиглах Дэлхийн хөндлөн меркатор UTM тусгагийн параметр
- “Геодезийн ажлын аюулгүйн техникийн дүрэм” УГЗЗГ, 1976 он

Зураг. 2.2.3.1 Байршлын тойм зураг



2.2.4. Геодезийн хуучин цэг тэмдэгтийн судалгаа

Урьд жилүүдэд байгуулсан геодезийн сүлжээний цэгүүдэд үзлэг тооллого хийх, түүний бүрэн бүтэн байдал, ашиглах боломжийг ажлын явцад судлахаар Төв аймгийн Жаргалант, Сэлэнгэ аймгийн Орхон сумдуудын 2014-2015 онуудад хийгдсэн “1:1000-ны масштабтай байрзүйн зургийн тодруулалт, шинэчлэлт хийх ажил”-ын GNSS-ийн зураглалын сүлжээний нийт 3 цэгийн утгыг ГЗБГЗЗГ-ын мэдээллийн төвөөс авч ашигласан (Зураг 2.1).

Эдгээрээс ажлын шаардлага хангасан устаж гэмтээгүй, байрлалын хувьд төслийн талбайд ойрхон байгаа 3 цэг тэмдэгтийн бүрэн бүтэн байдалд үзлэг хийж, хэмжилт хийх нөхцөл нь алдагдсан эсэхэд дүгнэлт өгч, байршлын тойм зураг шинээр үйлдэж, гэрэл зураг авах зэрэг ажил хийгдсэн (Хүснэгт 2.2.4.1, *Хавсралт 2.2.4.1*).

Хүснэгт 2.2.4.1.

Судалгаа хийж ашигласан цэг тэмдэгт

№	Цэгийн нэр, дугаар	Ашиглалтын байдал
1	ГЦТ-1054	Хэвийн
2	ГЦХ-0057	Хэвийн
3	ГТЦ-1145	Хэвийн

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг /Баянбулаг баг/, Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох 92.13км авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл



Хавсралт 2.2.4.1



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР


“Эрин кадастр” ХХК
(ААН-ын нэр)

Геодезийн цэгийн солбицол, өндрийн утга
(мэдээллийн утга)

2021-06-28

Д/д	Аймгийн нэр	Сумын нэр	Цэгийн дугаар	Өргөрөг	Уртраг	N_UTM	E_UTM	Өндөр
1	Сэлэнгэ	Орхон	ГЦТ-1145	49 08 35.20716	105 23 02.609638	5443436.190	528010.390	758.413
2	Төв	Талбулаг 3-р баг	ГЦЦ-1054	48 35 36.37991	105 57 23.15716	5382703.414	570523.090	992.619
3	Төв	Талбулаг 3-р баг	ГЦХ-41-0057	48 35 40.62309	105 56 38.54337	5382823.061	569607.697	984.628

ГБЗЗМэдээллийн сангийн мэргэжилтэн /С.Нарангэрэл/



Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар – Архив, мэдээллийн төв.

Зураг 2.2.4.1 Цэг тэмдэгтийн фото зураг

Цэгийн төв	Цэгийн орчны байдал
ГЦТ-1054	
	
ГЦХ-0057	
	
ГЦТ-1145	
	

Хээрийн судалгаагаар ажлын шаардлага хангасан төслийн талбайд байрлалын хувьд ойрхон 3 цэгт судалгаа хийж, үлдсэн 41 цэгүүдийг шинээр суулгасан (Хүснэгт 2.2.4.2, Зураг 2.2.4.1)

Хүснэгт 2.2.4.2

Судалгаа болон шинээр суулгах цэгүүд

№	Төлөвлөсөн цэг, тэмдэгт		Нийт
	Судалгаа хийгдсэн	Шинээр суулгах	
1	3	41	44

2.2.5 Шинээр цэг, тэмдэгт суулгах

Шинээр геодезийн байрлал болон өндрийн цэгийн төв болон реперийг Монгол улсын барилгын дүрэм “Геодезийн байнгын цэг, тэмдэгт байгуулах ажил” БД11-104-06*/16 дагуу суулгасан. Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн төрлийг ажлын төрөл, нарийвчлал, газар орчны физик газарзүйн нөхцөл, хөрсний шинж чанарыг харгалзан сонгосон.

Цэгийг суулгахдаа газрын хөрсний бүтэцтэй нарийвчлан танилцаж, цэгийн хийц, хэлбэрийг сонгосон.

Байрзүйн зураглалын талбайд байгаа геодезийн үндэслэлийн хуучин ба шинээр суулгах цэгүүдийн төв цэгийн болон орчны байрлалтай холбосон ойроос, холоос гэсэн хоёр байрлалын фото зургийг аппаратаар авч орчны тойм зураг, зайн хэмжээсийн байдал, байршлын тухай мэдээлэл, суулгаж, судалсан хугацаа, гүйцэтгэгч байгууллага, мэргэжилтнийг тусгасан цэг тэмдэгтийн хувийн хэргийг хийсэн.

2.2.6 GPS-ийн сүлжээний хэмжилт

“Хиймэл дагуул (GPS/ГЛОНАСС)-ын технологиор монгол улсын геодезийн сүлжээ байгуулах үндсэн дүрэм” БнБД 14-101-08-н

- Зураглалын сүлжээг хиймэл дагуул (GPS/ГЛОНАСС)-ын геодезийн харьцангуй аргаар солбицол тодорхойлох зарчмаар байгуулах бөгөөд цэг хоорондын харилцан байрлалын дундаж квадрат алдаа байрлалын хувьд **3см**, өндрийн хувьд **5см**-ээс ихгүй байна.
- Зураглалын сүлжээ хийх хүлээн авагч нь 2 долгионы сувагтай байх
- Дундаж квадрат алдааг илэрхийлэх томъёоны нэг дэх гишүүн нь 5 мм-ээс ихгүй,
- Бусад үзүүлэлт болох мэдээлэл дамжуулах оролтын тоо, зайнаас болон автоматаар удирдах боломж, тэжээлийн эх үүсвэртэй.
- Сүлжээний хэмжилтийн багаж геодези, хэмжил зүйн лабораториар баталгаажуулагдсан байх. (Хавсралт 3).

- Геодезийн сүлжээний хэмжилтийн ажилд ашиглах багаж бүрт урьдчилан хяналтын хэмжилт хийсэн.
- Цэг дээр хүлээн авагчийг оптик төвлөрүүлэгчээр 1 мм-ээс багагүй нарийвчлалтай төвлөрүүлсэн байх.
- Нэг төрлийн хүлээн авагчуудыг ашигласан байх.
- Хүлээн авагчид хэрэглэх тэжээлийн эх үүсвэр нь дор хаяж нэг хугацааны хэмжилтийн үргэлжлэх хугацаанд цэнэгээ алдахгүй үргэлжилсэн байх.

Зураг 2.2.6.1 Геодезийн цэг тэмдэгтийн гаднах тэмдэглэгээ



Цэгийн гаднах тэмдэглээс нь цэг, тэмдэгтийг эрж олох, удаан хугацаанд хадгалах үүрэгтэй. Гаднах тэмдэглээсийг газар орчны байдал, хөрсний шинж, геодезийн сүлжээний төрөл, анги, ажлын онцлог зэргийг харгалзан хийсэн. Сүлжээний цэгийн гаднах тэмдэглээсийг шуудуугаар тэмдэглэх бөгөөд П маягийн хэлбэртэй шуудууны нийт урт нь 6 м-ээс ихгүй, өргөн нь амсраараа 0.4 м, гүн нь 0.3 м, ёроолын өргөн нь 0.2 м байхаар ухсан.

Хавсралт 2.2.6.1

Геодезийн сүлжээний хэмжилтийн журналын загвар

Цэгийн нэр: Төвийн дугаар:

Аймаг, сумын нэр:

Трапецийн дугаар:

Маягт

Хүлээн авагчийн төрөл:	Давталт № 1		Давталт № 2	
	Эхэлсэн	Дууссан	Эхэлсэн	Дууссан
Огноо				
Хэмжилт хийсэн цаг (Улаанбаатарын цагаар)				
Хүлээн авагчийн өндөр (м-ээр)				
Хүлээн авагчийн дугаар				
Удирдлагын блокын дугаар				
Агаарын температур				
Агаарын даралт- паскаль				
Агаарын чийгшил- %				
Хэмжилт хийх үеийн хүлээн авагчийн өндөр хэмжсэн зураг болон фото зураг:			Хэмжилтийн үеийн нэмэлт мэдээлэл:	

Хэмжилт хийсэн: (Байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтны нэр)

2.2.7 GPS-ийн сүлжээний хэмжилтийн боловсруулалт

Геодезийн сүлжээний хэмжилтийн үр дүнг боловсруулах ажлын зорилго нь хэмжилтийн чанарын шалгалт хийх, хэмжилтийн нарийвчлал техникийн шаардлагад хэрхэн нийцэж байгааг тогтоох явдал байдаг.

GPS-ийн хэмжилтийн үр дүнг Trimble business center болон SOUTH STC программыг ашиглан дараах дарааллаар боловсруулсан. Үүнд:

- GPS-ийн хэмжилтийн эх мэдээлэлд хяналт хийх;

- GPS-ийн салангид векторуудын боловсруулалт;
- Векторуудын битүүрэлтийн алдаа болон векторын бодолтын үр дүнд анализ хийх;
- GPS-ийн сүлжээний тэгшитгэн бодолт зэрэг болно.

GPS-ийн сүлжээний полигонуудын битүүрэлтийн харьцангуй алдаа нь 1:100000-аас хэтрэхгүй байх шаардлагатай ба эх мэдээлэлд анализ хийх үед GPS-ийн хэмжилтийн станц дээр цуглуулах шаардлагатай антенны өндөр, цаг уурын өгөгдлүүд, станцын дугаар зөв өгөгдсөн эсэхийг хэмжилтийн журналтай харьцуулан шалгасан.

GPS-ийн сүлжээний векторуудын бодолтыг ашиглан GPS-ийн тэгшитгэн бодолтын ажлыг лицензтэй программ хангамжийг ашиглан гүйцэтгэсэн.

GPS-ийн сүлжээний хэмжилтийн тэгшитгэн бодолтын үр дүн болох X, Y, B, L солбицолыг, нивелирдлэгийн хэмжилтээр гарсан өндрийн жагсаалттай хамтатган Хүснэгт 2.2.7.1-т үзүүлэв.

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг /Баянбулаг баг/, Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох 92.13км авто замын трассын дагуух үндсэн реперүүдийн солбицол өндрийн жагсаалт

Хүснэгт 2.2.7.1

№	Цэгийн нэр, дугаар	Солбицол (WGS84, UTM49N)				Өндөр
		N_UTM	E_UTM	өргөрөг	уртраг	
1	BM-1	5379883.913	580782.445	48 34 00.62028	106 05 41.98887	1079.803
2	BM-2	5379783.694	578942.836	48 33 58.21898	106 04 12.16842	1049.883
3	BM-3	5380824.695	577294.228	48 34 32.66761	106 02 52.43211	1029.116
4	BM-4	5381486.233	575412.269	48 34 54.91481	106 01 21.02846	1014.443
5	BM-5	5381984.030	573337.569	48 35 11.92113	105 59 40.09045	1000.660
6	ГЦТ-1054	5382703.414	570523.090	48 35 36.37991	105 57 23.15716	992.619
7	ГЦХ-0057	5382823.050	569607.706	48 35 40.62273	105 56 38.54381	984.612
8	BM-6	5385859.595	567860.080	48 37 19.64354	105 55 15.01638	1048.733
9	BM-7	5386853.028	566006.528	48 37 52.52727	105 53 45.05004	1032.101
10	BM-8	5387468.168	563925.035	48 38 13.22559	105 52 03.70316	967.322
11	BM-9	5388745.948	562192.811	48 38 55.23257	105 50 39.75824	926.597
12	BM-10	5391450.043	560722.461	48 40 23.31922	105 49 29.32921	955.931

№	Цэгийн нэр, дугаар	Солбицол (WGS84, UTM49N)				Өндөр
		N_UTM	E_UTM	өргөрөг	уртраг	
13	BM-11	5393454.045	559806.084	48 41 28.53273	105 48 45.56697	927.693
14	BM-12	5394352.881	557650.830	48 41 58.36989	105 47 00.59937	955.385
15	BM-13	5395414.438	555174.865	48 42 33.55247	105 44 59.98323	936.131
16	BM-14	5397409.664	554746.674	48 43 38.29988	105 44 39.98482	950.478
17	BM-15	5397895.071	552602.876	48 43 54.68361	105 42 55.27231	930.330
18	BM-16	5399865.542	551906.291	48 44 58.70411	105 42 22.06612	911.624
19	BM-17	5401765.854	551019.443	48 46 00.50614	105 41 39.48483	920.016
20	BM-18	5402060.670	548989.362	48 46 10.64047	105 40 00.16305	937.996
21	BM-19	5402319.428	546963.157	48 46 19.58233	105 38 21.00501	996.982
22	BM-20	5404274.623	546302.814	48 47 23.07654	105 37 49.44574	1015.455
23	BM-21	5406441.922	546257.741	48 48 33.27311	105 37 48.11556	1036.178
24	BM-22	5408203.889	545231.668	48 49 30.60346	105 36 58.50741	1103.211
25	BM-23	5410208.130	544790.467	48 50 35.62254	105 36 37.65728	1184.261
26	BM-24	5412079.980	544045.806	48 51 36.43102	105 36 01.84722	1127.916
27	BM-25	5413947.840	544996.126	48 52 36.67259	105 36 49.22744	1047.360
28	BM-26	5415662.248	546154.669	48 53 31.88350	105 37 46.80314	1007.427
29	BM-27	5417609.597	545655.069	48 54 35.07748	105 37 23.05146	979.005
30	BM-28	5419333.813	544322.608	48 55 31.26106	105 36 18.26530	956.318
31	BM-29	5420312.358	542430.131	48 56 03.42673	105 34 45.62989	926.305
32	BM-30	5420907.030	540318.699	48 56 23.19234	105 33 02.06053	909.361
33	BM-31	5422537.399	538359.464	48 57 16.43740	105 31 26.30191	870.994
34	BM-32	5424252.251	537212.187	48 58 12.22214	105 30 30.45211	844.508
35	BM-33	5425975.334	536169.012	48 59 08.24395	105 29 39.69252	834.174
36	BM-34	5427621.601	534800.059	49 00 01.83841	105 28 32.84342	817.320
37	BM-35	5429167.107	533390.015	49 00 52.16714	105 27 23.90163	795.856
38	BM-36	5430444.952	532200.954	49 01 33.77532	105 26 25.72718	782.725
39	BM-37	5432129.164	531114.464	49 02 28.51616	105 25 32.69020	768.959
40	BM-38	5433326.089	529748.503	49 03 07.51913	105 24 25.72157	773.452
41	BM-39	5435449.720	528606.640	49 04 16.48357	105 23 30.00320	759.723
42	BM-40	5437325.307	528502.631	49 05 17.23810	105 23 25.35273	735.317

№	Цэгийн нэр, дугаар	Солбицол (WGS84, UTM49N)				Өндөр
		N_UTM	E_UTM	өргөрөг	уртраг	
43	BM-41	5439425.220	528484.824	49 06 25.24238	105 23 25.00781	731.541

2.2.8. Нивелирдлэгийн III ангийн хэмжилт, боловсруулалт

Төслийн талбайд ашиглагдах хуучин болон шинээр суулгасан сүлжээний цэгүүд дээр өндрийг тодорхойлохдоо ажлын талбайд ойр байгаа GNSS, болон гравиметрийн цэгүүдэд тулгуурлан нивелирдлэгийн III ангийн нарийвчлалаар өндрийн сүлжээний хэмжилт боловсруулалт хийсэн.

Нивелирдлэгийн хэмжилтийг Хятад улсын SOUTH фирмийн DL-202 маркийн 1 км нүүлтийн шууд урвууд 1 мм-ийн нарийвчлалтай компенсатортой нивелирээр 5 метрийн эвхдэг 2 рейк, башмак ашиглан хийсэн.

Рейкнээс багаж хүртлэх хамгийн их зайг 100 метрээс хэтрүүлэхгүй бөгөөд утаа униар, зэрэглээ, салхигүй тогтуун байх үед нивелирдлэгийн хэмжилтийг хийж гүйцэтгэсэн.

Нивелирдлэгийн III ангийн хэмжилтийг хатуу цэгийн хооронд шууд урвуу чиглэлд задгай сэлгэцийн аргаар хийсэн. Нийт 3 сэлгэцэд хувааж, задгай сэлгэцийн аргаар тэгшитгэн бодсон.

Нүүлтийн зөвшөөрөгдөх алдааг $зөвшf_n = \pm 10 \text{ мм} \sqrt{L}$ томъёогоор тооцсон.

Энд L нь нүүлтийн уртыг км-ээр авсан тоо болно.

Жаргалант сумын ГЦТ-1054, Орхон сумын ГЦТ-1145 цэгүүдийн хооронд задгай сэлгэцээр өндөр дамжуулсан боловч өндөржилтийн зөрүү зөвшөөрөгдөх хэмжээнээсээ их байсан учир хэмжсэн өндөржилтийн утгаар өндрийг бодож гаргав. (Хүснэгт 2.2.8.1).

III ангийн нивелирдлэгийн бодолт. Сэлгэц1 BM1-BM41

Хүснэгт 2.2.8.1

Д/д	Марк, реперийн дугаар	Секцийн урт, км	Өндөржилт, м	Засвар, м	Засварласан өндөржилт, м	Өндөр, м
1	BM1					1079.803
		1.9	-29.920		-29.920	
2	BM2					1049.883
		2.0	-20.767		-20.767	
3	BM3					1029.116
		2.1	-14.673		-14.673	
4	BM4					1014.443
		2.25	-13.783		-13.783	
5	BM5					1000.660
		3.05	-8.041		-8.041	
6	ГЦТ-1054					992.619

		1.0	-8.007		-8.007	
7	ГЦХ-0057					984.612
		3.65	+64.121		+64.121	
8	BM6					1048.733
		2.2	-16.632		-16.632	
9	BM7					1032.101
		2.25	-64.779		-64.779	
10	BM8					967.322
		2.25	-40.725		-40.725	
11	BM9					926.597
		3.2	+29.334		+29.334	
12	BM10					955.931
		2.26	-28.238		-28.238	
13	BM11					927.693
		2.47	+27.692		+27.692	
14	BM12					955.385
		2.78	-19.254		-19.254	
15	BM13					936.131
		2.13	+14.347		+14.347	
16	BM14					950.478
		2.28	-20.148		-20.148	
17	BM15					930.330
		2.3	-18.706		-18.706	
18	BM16					911.624
		2.29	+8.392		+8.392	
19	BM17					920.016
		2.17	+17.980		+17.980	
20	BM18					937.996
		2.14	+58.986		+58.986	
21	BM19					996.982
		2.19	+18.473		+18.473	
22	BM20					1015.455
		2.29	+20.723		+20.723	
23	BM21					1036.178
		2.14	+67.033		+67.033	
24	BM22					1103.211
		2.3	+81.050		+81.050	
25	BM23					1184.261
		2.11	-56.345		-56.345	
26	BM24					1127.916
		2.2	-80.556		-80.556	
27	BM25					1047.360

		2.21	-39.933		-39.933	
28	BM26					1007.427
		2.14	-28.422		-28.422	
29	BM27					979.005
		2.29	-22.687		-22.687	
30	BM28					956.318
		2.28	-30.013		-30.013	
31	BM29					926.305
		2.34	-16.944		-16.944	
32	BM30					909.361
		2.71	-38.367		-38.367	
33	BM31					870.994
		2.15	-26.486		-26.486	
34	BM32					844.508
		2.12	-10.334		-10.334	
35	BM33					834.174
		2.27	-16.854		-16.854	
36	BM34					817.320
		2.2	-21.464		-21.464	
37	BM35					795.856
		1.86	-13.131		-13.131	
38	BM36					782.725
		2.15	-13.766		-13.766	
39	BM37					768.959
		2.0	+4.493		+4.493	
40	BM38					773.452
		2.59	-13.729		-13.729	
41	BM39					759.723
		1.98	-24.406		-24.406	
42	BM40					735.317
		2.19	-3.776		-3.776	
43	BM41					731.541

2.2.9. Байр зүйн зургийн хээрийн хэмжилт, боловсруулалт

Зураглалын ажлыг байрлал, өндрийн хувьд WGS-84 солбицлын тогтолцоо, UTM тусгаг, их хагас тэнхлэг 6378137 м, шахцал 1:298.25722101-г ашиглан балтийн тэнгисийн өндрийн тогтолцоонд гүйцэтгэсэн. 1:1000-ны масштабтай, 0.5 метрийн үеийн өндөртэй байр зүйн зураглалын ажлыг хийж гүйцэтгэсэн. Хээрийн хэмжилтийг GPS-ийн RTK горимоор хийж гүйцэтгэсэн.

2.2.10 Ажлын хяналт, шалгалт

Ажлын бүх үе шатанд дотоодын хяналт шалгалтыг хээрийн болон суурин нөхцөлтэй үед гүйцэтгэж, ажлын чанарт онцгой анхааран ажиллав.

Хээрийн хэмжилтийн үед инженер техникийн ажилчдад ажлын зохион байгуулалт, аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг танилцуулан, ажлын холбогдох техникийн даалгавар, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдүүлэн ажилласан болно.

Хээрийн ажил эхлэхийн өмнө өдөр бүр дараах бэлтгэлийг хангаж ажиллав. Үүнд:

- GPS, нивелир, рейк, багажны хөлний бүрэн бүтэн эсэх,
- Тэжээлийн эх үүсвэр болох батарей ажиллагаатай эсэх,
- Хэмжилтийн өгөгдөлийг хадгалах санах ойн багтаамжийг шалгах,
- Автомашины бүрэн бүтэн байдлыг шалгах,
- Хэмжилтийн ажлыг эхлэхээс өмнө тухайн ажлын шугамд хамаарагдаж байгаа
- репер, цэг тэмдэгтүүдийг бүрэн судлаж, сэргээн босголт хийгдсэн эсэх,
- Цэгүүдийн хувийн хэргийн бүртгэл үнэн зөв үйлдэгдсэн эсэх,
- Хээрийн хэмжилтийн хуудасны шалгалтын үр дүнг шалгасан эсэх,

2.3 ЗАМЫН ДАГУУХ БУУРЬ ХӨРСНИЙ СУДАЛГАА

Судалгааны талбайд тархсан хөрс, чулуулгийг нас, гарал үүсэл, шинж чанараас нь хамааруулан инженер-геологийн 7 элементэд ангилан үзэж болно. Үүнд:

Сэвсгэр хөрс:

- ИГЭ-1. Жижиг ширхэгтэй элс
- ИГЭ-2. Хайргархаг элс
- ИГЭ-3. Элсэнцэр чигжээстэй хайрга
- ИГЭ-4. Шавранцар хурдас
- ИГЭ-5. Хайргархаг шавранцар

Хадан чулуулаг:

- ИГЭ-6. Элсэн чулуу
- ИГЭ-7. Боржин чулуу

ИГЭ-1. Жижиг ширхэгтэй элс

Бор саарал, бор шаргал өнгөтэй, бага чийгтэй-чийгтэй жижиг ширхэгтэй элсэн хөрсний ширхэгийн бүрэлдэхүүний дундаж утгыг тодорхойлбол (%):

• Хайрга	2.5
• Элс	82.5
• Тоос	10.1
• Шавар	4.9 тус тус агуулагдана.

Элсэн хөрсний физик шинж чанарын үзүүлэлтийн дундаж утгыг тодорхойлбол:

• Байгалийн чийг	0.065
• Эрдэслэг хэсгийн нягт, г/см ³	2.65
• Байгалийн нягт, г/см ³	1.64
• Хатуу хэсгийн нягт, г/см ³	1.54
• Сүвшил, %	41.78
• Сүвшлийн итгэлцүүр	0.718
• Чийглэгийн зэрэг	0.24

Механик шинж чанарын үзүүлэлтийн тооцооны утгыг АЗУАГН 2.01.01-2004-өөр өгвөл:

• Зууралдлын хүч	C=0.005 МПа
• Дотоод үрэлтийн өнцөг	φ=38°
• Хэв гажилтын модуль	E=100 МПа

Элс нь АЗУАГН 2.01.01-2004-өөр сул овойлттой хөрсөнд нормчилогдоно.

Газар шорооны ажлын зэрэг нь гэсгэлэн нөхцөлд гар аргаар – I.

ИГЭ-2. Хайргархаг элс

Бор саарал, бор шаргал өнгөтэй, бага чийгтэй – усаар ханасан хайргархаг элсэн хөрсний ширхэгийн бүрэлдэхүүний дундаж утгыг тодорхойлбол(%):

• Хайрга	36.0
• Элс	53.0
• Тоос	7.4
• Шавар	3.6 тус тус агуулагдана.

Хайргархаг элсэн хөрсний физик шинж чанарын үзүүлэлтийн дундаж утгыг тодорхойлбол:

• Байгалийн чийг	0.056
• Эрдэслэг хэсгийн нягт, г/см ³	2.69
• Байгалийн нягт, г/см ³	2.11
• Хатуу хэсгийн нягт, г/см ³	2.00
• Сүвшил, %	25.71
• Сүвшлийн итгэлцүүр	0.348
• Чийглэгийн зэрэг	0.41

Механик шинж чанарын үзүүлэлтийн тооцооны утгыг АЗУАГН 2.01.01-2004-өөр өгвөл:

• Зууралдлын хүч	C=0.005 МПа
------------------	-------------

- Дотоод үрэлтийн өнцөг $\varphi=42^{\circ}$
- Хэв гажилтын модуль $E=130$ МПа

Хайргархаг элс нь АЗУАГН 2.01.01-2004-өөр сул овойлттой хөрсөнд нормчилогдоно.

Газар шорооны ажлын зэрэг нь гэсгэлэн нөхцөлд гар аргаар – III.

ИГЭ-3. Элсэнцэр чигжээстэй хайрга

Бор шаргал, бор саарал өнгөтэй, хатуу консистенцтэй элсэнцэр чигжээстэй хайрган хөрсний ширхэгийн бүрэлдэхүүний дундаж утгыг тодорхойлбол (%):

- Хайрга 52.5
- Элс 33.1
- Тоос 8.7
- Шавар 5.7 тус тус агуулагдана.

Элсэнцэр чигжээстэй хайрган хөрсний физик шинж чанарын үзүүлэлтийн дундаж утгыг тодорхойлбол:

- Байгалийн чийг 0.084
- Урсалтын хязгаар дахь чийг 0.194
- Имрэгдлийн хязгаар дахь чийг 0.146
- Уян налархайн тоо 0.048
- Эрдэслэг хэсгийн нягт, г/см³ 2.71
- Байгалийн нягт, г/см³ 2.23
- Хатуу хэсгийн нягт, г/см³ 2.05
- Сүвшил, % 24.14
- Сүвшлийн итгэлцүүр 0.318
- Чийглэгийн зэрэг 0.72
- Консистенц <0

Механик шинж чанарын үзүүлэлтийн тооцооны утгыг АЗУАГН 2.01.01-2004-өөр өгвөл:

- Зууралдлын хүч $C=0.045$ МПа
- Дотоод үрэлтийн өнцөг $\varphi=32^{\circ}$
- Хэв гажилтын модуль $E=108$ МПа

Элсэнцэр чигжээстэй хайрга нь АЗУАГН 2.01.01-2004-өөр хүчтэй овойлттой хөрсөнд нормчилогдоно.

Газар шорооны ажлын зэрэг нь гэсгэлэн нөхцөлд гар аргаар – III.

ИГЭ-4. Шавранцар

Бор шаргал бор саарал өнгөтэй, хатуу – зөөлөн уян налархай консистенцтэй шавранцар хөрсний ширхэгийн бүрэлдэхүүний дундаж утгыг тодорхойлбол (%):

• Хайрга	8.8
• Элс	49.9
• Тоос	27.1
• Шавар	14.2 тус тус агуулагдана.

Шавранцар хөрсний физик шинж чанарын үзүүлэлтийн дундаж утгыг тодорхойлбол:

• Байгалийн чийг	0.121
• Урсалтын хязгаар дахь чийг	0.247
• Имрэгдлийн хязгаар дахь чийг	0.126
• Уян налархайн тоо	0.121
• Эрдэслэг хэсгийн нягт, г/см ³	2.71
• Байгалийн нягт, г/см ³	1.79
• Хатуу хэсгийн нягт, г/см ³	1.60
• Сүвшил, %	40.91
• Сүвшлийн итгэлцүүр	0.694
• Чийглэгийн зэрэг	0.47
• Консистенц	0.27

Механик шинж чанарын үзүүлэлтийн тооцооны утгыг АЗУАГН 2.01.01-2004-өөр өгвөл:

• Зууралдлын хүч	C=0.015 МПа
• Дотоод үрэлтийн өнцөг	$\varphi=15^{\circ}$
• Хэв гажилтын модуль	E=34 МПа

Шавранцар нь АЗУАГН 2.01.01-2004-өөр хэтэрхий овойлттой хөрсөнд нормчилогдоно.

Газар шорооны ажлын зэрэг нь гэсгэлэн нөхцөлд гар аргаар – II.

ИГЭ-5. Хайргархаг шавранцар

Бор шаргал бор саарал өнгөтэй, хатуу – зөөлөн уян налархай консистенцтэй хайргархаг шавранцар хөрсний ширхэгийн бүрэлдэхүүний дундаж утгыг тодорхойлбол (%):

• Хайрга	40.7
• Элс	26.9
• Тоос	20.5

- Шавар 11.9 тус тус агуулагдана.

Хайргархаг шавранцар хөрсний физик шинж чанарын үзүүлэлтийн дундаж утгыг тодорхойлбол:

• Байгалийн чийг	0.139
• Урсалтын хязгаар дахь чийг	0.217
• Имрэгдлийн хязгаар дахь чийг	0.129
• Уян налархайн тоо	0.088
• Эрдэслэг хэсгийн нягт, г/см ³	2.72
• Байгалийн нягт, г/см ³	2.16
• Хатуу хэсгийн нягт, г/см ³	1.90
• Сүвшил, %	30.19
• Сүвшлийн итгэлцүүр	0.433
• Чийглэгийн зэрэг	0.87
• Консистенц	0.33

Механик шинж чанарын үзүүлэлтийн тооцооны утгыг АЗУАГН 2.01.01-2004-өөр өгвөл:

• Зууралдлын хүч	C=0.013 МПа
• Дотоод үрэлтийн өнцөг	φ=15 ⁰
• Хэв гажилтын модуль	E=38 МПа

Хайргархаг шавранцар нь АЗУАГН 2.01.01-2004-өөр хэтэрхий овойлттой хөрсөнд нормчилогдоно.

Газар шорооны ажлын зэрэг нь гэсгэлэн нөхцөлд гар аргаар – III.

ИГЭ-6. Элсэн чулуу /хадан хөрс/

Байгалийн нягт, г/см ³		Өгөршлийн зэрэг	Газар шорооны ажлын зэрэг		Нэгэн чиглэлийн шахагдалд үзүүлэх түр зуурын эсэргүүцэл, МПа
өгөршөөгүй	өгөршсөн		өгөршөөгүй	өгөршсөн	
2.73	2.34	0.86	VII	V	R _c =25

ИГЭ-7. Боржин чулуу /хадан хөрс/

Байгалийн нягт, г/см ³		Өгөршлийн зэрэг	Газар шорооны ажлын зэрэг		Нэгэн чиглэлийн шахагдалд үзүүлэх түр зуурын эсэргүүцэл, МПа
өгөршөөгүй	өгөршсөн		өгөршөөгүй	өгөршсөн	
2.72	2.36	0.87	VII	V	R _c =15

2.3.1 Замын дагуух хөрсний физик болон механик шинж чанар

1. Төлөвлөж буй авто замын зурвас нь инженер-геологийн **дунд зэрэг** нөхцөлтэй талбайд хамаарна.
2. Сэвсгэр хөрсний механик шинж чанарын тооцооны үзүүлэлтийг (АЗУАГН 2.01.01-2004-өөр) өгвөл:

Хөрсний нэр	Зууралдлын хүч	Дотоод үрэлтийн өнцөг	Хэв гажилтын модуль	Хөрсний бүлэг	Харьцангуй овойлт %/
	С хөрс /МПа/	φ хөрс /град/	Е хөрс /МПа/		
ИГЭ-1. Жижиг ширхэгтэй элс	0.005	38	100	II	1-4
ИГЭ-2. Хайргархаг элс	0.005	42	130	II	1-4
ИГЭ-3. Элсэнцэр чигжээстэй хайрга	0.045	32	108	IV	7-10
ИГЭ-4. Шавранцар	0.015	15	34	V	>10
ИГЭ-5. Хайргархаг шавранцар	0.013	15	38	V	>10

3. Хадан хөрсний үзүүлэлтийг өгвөл:

Хөрсний нэр	Байгалийн нягт, г/см ³		Өгөршлийн зэрэг	Газар шорооны ажлын зэрэг		Нэгэн чиглэлийн шахагдалд үзүүлэх түр зуурын эсэргүүцэл, МПа
	өгөршөөгүй	өгөршсөн		өгөршөөгүй	өгөршсөн	
ИГЭ-6. Элсэн чулуу	2.73	2.34	0.86	VII	V	R _c =25
ИГЭ-7. Боржин чулуу	2.72	2.36	0.87	VII	V	R _c =15

4. Судалгааны талбайд тархсан хөрсний овойлтын хүч, газар шорооны ажлын зэрэг, хөрсний хувийн цахилгаан эсэргүүцлийн /лавлахаас/ утгыг хүснэгтэд үзүүллээ.

Хөрсний нэр	Овойлтын зэрэг	Газар шорооны ажлын зэрэг	Хувийн цахилгаан эсэргүүцэл, Ом.м	
			устай	усгүй

